



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/847

Улаанбаатар хот


Журамд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ИНД-171.53.г дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/828 дугаар тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх журам"-ын 2.1 дэх хэсгийн "НААХЗГ" гэснийг "НААХЗА", 3.2, 6.1, 6.2, 6.3, 6.5, 6.6, 8.1 хэсгүүдэд "хэлтэс" гэснийг "газар", 4.2 дахь хэсэгт "Чиглэлийн нислэгт ашиглах навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, үйлчилгээг Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу зөвхөн Техник хангалт, навигацийн үйлчилгээний алба нь хариуцах нөхцөлд гэрчилгээ олгогдоно." гэснийг "Чиглэлийн нислэгт ашиглах навигаци болон ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, үйлчилгээг Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийг баримтлан гэрчилгээг олгоно.", 5.5 дахь хэсэгт "Иргэний нисэхийн радио навигацийн болон бодит ажиглалтын системийн байгууламжид ИКАО-ын Док 8071-д заагдсаны дагуу эрх бүхий байгууллага /Шалгалтын нислэг, зураглалын алба/ нь газрын үзлэг, шалгалт, тохиргоо, хүлээн авах шалгалтын нислэгийг гүйцэтгэж, дүгнэлт гаргасан байна." гэснийг "Иргэний нисэхийн радио навигацийн болон бодит ажиглалтын системийн байгууламжид ИКАО-ын Док 8071-д заагдсаны дагуу "Шалгалтын нислэгт тавигдах шаардлага"-д нийцсэн эрх бүхий байгууллага нь хүлээн авах шалгалтын нислэгийг гүйцэтгэж, дүгнэлт гаргасан байна.", 9.1 дэх хэсэгт "Тоног төхөөрөмжүүдийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн үед Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсээс шийдвэрлэсний дагуу орон нутгийн нисэх буудлын дарга болон Тоног төхөөрөмжийн гэрчилгээ эзэмшигч байгууллагын дарга нар Гэрчилгээний "Тоног төхөөрөмжийн байршил" хэсэгт шилжилтийн хөдөлгөөнийг хийнэ." гэснийг "Тоног төхөөрөмжүүдийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн үед ИНД-171-ээр гэрчилгээжсэн техникийн байгууллага нь шилжилтийн бүртгэлийг хийнэ." гэж тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Мөн журмын 6.2 дахь хэсэгт шинээр "4.2-т заагдсан тоног төхөөрөмжүүд ИНЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байх ба нисэх буудлын зориулалттай тоног төхөөрөмжүүд нь тухайн төхөөрөмжийг эзэмшигчийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн байна." заалтыг нэмсүгэй.

3. Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг Холбоо, навигаци, ажиглалтын алба /Д.Баяртогтох/, Оношилгоо хэмжил зүйн лаборатори /Г.Батцэцэг/, Орон нутгийн нисэх буудлуудын дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.



Л.БЯМБАСҮРЭН